

Дорнод Монголын неолитын үеийн хүний дүрст чулуун “онго”-ын судалгаа

Даваахүүгийн Одсүрэн^{1,2,*}, Лиза Яанз³, Адъяасүрэнгийн Алтанбагана¹,
Баатарын Цэнгэл⁴, Хүүхэндүүгийн Сувдаа¹

Товч агуулга: Энэ өгүүлэлд Хэрлэн голын савд орших Норовлин уулын неолитын булш, Дорнод Монголын тал, хээрийн өмнөд хэсэгт орших Молцог элсний Өлзийтийн булгийн Шар манхан, Цагаан толгойн суурингаас илрүүлсэн хүний нүүрний дүрст чулуун онгыг бүс нутгийн ижил төстэй хэрэглэгдэхүүн, хадны зурагтай харьцуулан авч үзжээ. Зүүн Азийн анчин-түүвэрлэгчдийн дунд өвөг дээдсийг шүтэх шүтлэгтэй холбоотойгоор хүний нүүрний дүрсийг хад чулуунаа урлах явдал палеолитын төгсгөлд буй болжээ. Неолитын үеийн байгаль, цаг уурын таатай нөхцөл, аж ахуйн хөгжилтөөр хүн амын төвлөрөл бүхий суурьшмал амьдралын хэв маяг үүсэж хөгжин, нийгмийн шүтлэгийн хэрэгцээ өсөн нэмэгдсэнээр өвгөдийн шүтлэг, зан үйл, ёслол улам гүнзгийрч өргөн дэлгэрчээ. Энэ үеэс хүний нүүрний дүрслэл шавар урлал, эдлэлд нэвтэрсэн байна. Улмаар тус бүс нутгийн оршин суугчдын ахуй амьдралын хэв маяг, түүхий эдийн чанар, хэрэглээнээс шалтгаалж чулуу, яс, хясаагаар хүний нүүрний дүрс урлах болжээ. Дорнод Монгол, Зүүн хойд Хятад, Алс Дорнодыг бүс нутгийг хамарсан неолитын үеийн соёлын энэ үзэгдэл Зүүн Азийн бүс нутгийн хэмжээнд тархмал нийтлэг шинжтэй боловч орон нутгийн онцлогтой ажээ.

Түлхүүр үг: Неолит, онго, шүтлэг, хүн

Удиртгал

Дээд палеолитын үеийн хүний ухамсар – сэтгэлгээний хөгжилт, нийгмийн оюун санааны амьдралын өөрчлөлт тэр үеийн урлагийн дурсгал хадны зураг, чулуу, ясан эдлэлд тусаж үлджээ. Европ, Ойрх Дорнодын дээд палеолитын үеийн дурсгалаас олддог “Венера” хэмээх чулуу, ясан сийлбэр эх (эмэгтэй) хүнийг шүтэх шүтлэгийн тод илрэл болдог билээ. Манай улсын нутгаас үүнтэй ижилсэх дурсгал одоогоор олдоогүй ч Сэлэнгэ мөрний дунд урсгал Их Төлбөрийн голын 21-р суурингийн 40 мянган жилийн өмнөх үед холбогдох давхаргаас эр хүний бэлэг эрхтэн дүрсэлсэн чулуун эдлэл олдсон байна (Rigaud et al. 2023: 1-13). Европын дээд палеолитын агуйн зурагт ан амьтны дүрслэл давамгайлж, хүний дүрслэл цөөн байдаг онцлогтой. Гэхдээ дээд палеолитын турш хүн гарын алгаа дүрслэн зурж байсан нь дэлхийн олон бүс нутгаас илэрч олдсон байна. Монгол Улс, түүнтэй хил залгаа хөрш зэргэлдээ бүс нутгаас ч ийм төрлийн зосон зургийг илрүүлж, судалгааны эргэлтэд оруулжээ (Төрбат нар 2023: 27-35). Ийнхүү гарын алгыг зурж

үлдээсэн нь амьтны аймгаас хүний ялгарах гол онцлог болсон гар, түүний ахуй амьдралын бүхий л зүйлд гүйцэтгэх үүрэг ролиос түүнийг бишрэх байдал үүсэж, улмаар хаднаа тусгайлан дүрсэлсэн болов уу.

Монголын хадны зосон зургийн гараа өргөн эгнэж зогссон хүмүүс, солбисон тэмдэг (х), эгнээ босоо зураас, геометрийн элдэв дүрс неолитын үеийн анчин – түүвэрлэгчдийн шүтлэг, зан үйлийн нэг хэсэг юм (Одсүрэн 2024: 26-36). Мөн Жавхлант хайрхан (Цэвээндорж нар 2004), Чулуутын хавцал (Новгородова 1989: 89-109) зэрэг хадны сийлмэл зургийн дурсгал дахь хүнийг олон янзаар дүрсэлсэн неолитын дунд, төгсгөл үеийн зураг, түүнчлэн хүний нүүрний зургууд цөм шүтлэг бишрэлийн агуулгатай. Монгол орны говийн бүс нутаг, түүнтэй хаяа нийлэх Умард Хятадын нутаг ийм сийлмэл зургийн томоохон төв болж байна (Амартүвшин нар 2020: 7-38). Хадны зурагт хүн, хүний нүүрний баг дүрслэхээс гадна чулуугаар хүний нүүр сийлбэрлэж, шүтээний бодит төлөөлөл “Онго” хийж байсан баримт Дорнод Монголын неолитын булш оршуулга, бууц суурины үлдэгдлээс цөөн боловч илрүүлээд байна. Тиймээс энэ өгүүлэлд хүний нүүрний дүрст чулуун онгын үүсэл, дүр, дүрслэлийн онцлог, соёл, он цагийн холбогдол, шүтлэгийн асуудлыг бүс нутгийн хэрэглэгдэхүүнд тулгуурлан тодруулахыг зорив.

¹ МУБИС, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Түүхийн тэнхим

² ШУА, Археологийн хүрээлэн

³ Канадын Торонтогийн Их Сургууль, Антропологийн тэнхим

⁴ МУИС, ШУС, Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхим

* Холбоо барих зохиогч: odsuren1983@gmail.com

<https://orcid.org/0000-0001-7215-3995>

Судалгааны эх хэрэглэгдэхүүн

Өнөөгийн байдлаар Монгол Улсын нутгаас “хүний нүүр дүрсэлсэн чулуун онго” гурвыг илрүүлж олоод байна. Эхнийх нь “Норовлингийн чулуун онго” нэрээр Монголын археологийн судалгаанд алдаршсан эдлэл юм. 1972 онд Монгол-Зөвлөлтийн геологийн экспедицийн ажилтан В.П.Дергач Дорнод аймгийн Булган сумын нутаг Хэрлэн голын баруун эргийн Норовлин ууланд ажиллахдаа үерийн усанд булхагдаж ил гарсан нэгэн булшнаас уг чулуун онгыг олж археологич В.В.Волковт авчирч өгчээ (Волков 1975: 76-79). Энэ булшийг В.В.Волков, Н.Сэр-Оджав нар малтан судалж тодорхойлсон байна.

“Норовлингийн чулуун онго”-ыг цайвар өнгөтэй, цахиурлаг чулуугаар хийжээ. Хэмжээ нь 22.1 см урт, 3.5 см өргөн, 1.4 см зузаан (Одсүрэн 2021: 185). Урт гонзгой чулуунд хүний нүүрний төрхийг чадмаг урласны дараа сайтар зүлгэж өнгөлжээ. Ингэхдээ чулууны дээд, доод үзүүрийг өндөр төвгөр дух болон нарийн шувтан эрүү, шонтон болгож засчээ. Чулуун онгонд дүгрэг том нүдийг хонхойлон ухаж урласан ба түүний зах ирмэг зовхи болж товойж үзэгдэнэ. Мөн урт тахир хөмсөг, түүнийг дагасан үрчлээг хос нарийн зураасаар дүрсэлжээ. Хамрыг хоёр нүдний дундаас эхлүүлэн үзүүр рүү аажим өргөсгөж, төгсгөлд нь захын хоёр ирмэгт хүртэл хөндлөн товгор гаргажээ. Нүдний аяганы доод хэсэг, хамрын хоёр талд ховил гаргаж доод зовхи, хацар, хамрыг тодруулсан байна. Хамрын доод талд хүн хонхор, жижиг уруул, ам дүрсэлжээ. Онгын дээд үзүүрт оосорлож зүүх зориулалттай нүх гаргаж, доод хэсгийн хоёр хажуу ирмэгт (эрүүнд) тус бүр дөрөв, нийт найман хэрчлээс гаргажээ. Урт гонзгой чулууны хэлбэрт хүний нүүрийг нарийн зохиомжтой урласан нь урлаачийн мэдрэмж, ур чадварыг илтгэнэ. Чулуун онгонд наалдаж үлдсэн улаан зосыг эрдэмтэд оршуулгын үеэр булшинд цацсан зосны үлдэгдэл хэмээн үзэж иржээ (Зураг 1).

Удаах чулуун онгыг Сүхбаатар аймгийн Наран сумын нутаг Молцог элсний ар биеэс ундардаг Өлзийт булагийн Шар манханы ар хунхаас Дарьганга сумын ахмад багш Д.Дугарсүрэн олж цуглуулгадаа хадгалж байна. 2024 оны зун “Товь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” төслийн ажлын явцад Д. Одсүрэн ахмад багш Д.Дугарсүрэнтэй танилцаж, түүний цуглуулгаас уг чулуун онгыг анх таньж тодорхойлсон юм.

Судалгаанд шинээр нэмэгдэж байгаа энэ эдлэлд “Өлзийтийн Шар манханы чулуун онго” нэр өгч байна.


Энэ чулуун эдлэлийг олон хонхор нүхтэй, галт уулын цайвар саарал өнгийн барзгар хүрмэн чулуугаар хийжээ. Хэмжээ нь 10 см урт, 7,7 см өргөн, 3,3 см зузаан. Энэхүү зууван дугуй, нимгэн чулууны зах



Зураг 1. Норовлингийн чулуун онго
(Дорнод аймаг, Булган сум. Норовлин уулын булш)

ирмэгийг мөлийлгөн засаж, өргөн тал дээр ялимгүй төвгөр духтай, унжуу гурвалжин нүдтэй, навтгар хамартай, жижиг амтай хүний нүүрийг тойм байдлаар дүрсэлжээ. Хамрын хажуу хоёр талыг уртаар хонхойлон хацрыг зааглаж харуулжээ. Хамрын доор хонхойлон цохиж ам дүрсэлжээ. Чулуун онгын ар болон хоёр хажуу талд ямар нэг дүрслэлгүй. Түүвэр байдлаар олдсон энэ чулуун онгын нүүр, ар талд бүдэг улаан зосны ор байгаа нь зориуд будсаныг илтгэнэ (Зураг 2). Энэ нь чулуун онгын үүрэг зориулалт-утга зүйн асуудалд холбогдолтой чухал баримт болж байна.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаач С.Далантай, Я.Цэрэндагва нар Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын нутаг Дунд зээрдийн уулын Цагаан толгойгоос нэгэн чулуун онго илрүүлснээ “Монголын археололги – 2024” хуралд танилцуулснаас гадна “Монголын археологийн мэдээ” сэтгүүлийн 2024 оны дугаарт товч мэдээ, гэрэл зургийн хамт хэвлүүлсэн юм. Энэ эдлэл нэг тал руугаа ялимгүй шувтан зууван хэлбэртэй агаад урт гонзгой нүүрийг ихэд бодитой урлажээ. Хүнийг хүнхэр нүдтэй, унжуу



Зураг 2. Өлзийтийн Шар манхны чулуун онго (Сүхбаатар аймаг, Наран сум, Өлзийт булагийн Шар манханы неолитын суурин)

өргөн хамартай, зууван дугуй уруултай дүрслэлжээ. Эрүүний шонтонг төгсгөлд нь гаргасан байна. Хажуу ар талд ямар нэг дүрслэл байхгүй (Зураг 3). Уншигчдад ойлгомжтой байлгах үүднээс энэ чулуун эдлэлийг “Цагаан толгойн чулуун онго” гэж бичив. Гэхдээ зөвхөн тус өгүүлэлд ийнхүү нэрлэж байгааг тэмдэглэе. Цаашид илрүүлж олсон судлаачид уг онгын нэрийг хэвшүүлэх болов уу. Дорнод Монголоос илэрч олдсон хүний нүүрний дүрс бүхий гурван чулуун онго өгүүллийн үндсэн хэрэглэгдэхүүн болов.

Чулуун онгын судалгааны асуудал

Чулуун онгын дүр, дүрслэлийн арга барил. Дорнод Монголын эдгээр чулуун онго олдсон газар нутаг хоорондоо зайтай, материал адилгүй, ур хийцийн хувьд ялгаатай боловч тэдгээрт дүрсэлсэн хүний нүүрний ерөнхий төрх, түүнийг үзүүлсэн арга барил ерөнхийдөө төстэй. Товчоор хэлбэл, хүний нүүрний хэлбэрт тохируулан урт гонзгой, зууван дугуй чулуу сонгож өргөн төвгөр хэсэгт нь рельефийн¹ аргаар хүний нүүрийг бүтнээр, бүдүүвчлэн дүрсэлсэн явдал юм. Тэгэхдээ дүрслэлийн хязгаарлагдмал талбайд төвгөр дух, том нүд, навтгар өргөн хамар, жижиг амыг бодитой харуулсан бөгөөд нүдний аяганы

доогуур, хамрын хоёр талыг уртаар хонхойлон нүд, хамар, хацрын заагийг мэдэгдэхүйц гаргаж өгчээ. Тийнхүү эдгээр чулуун онгод зөвхөн хүний нүүр төрхөнд ач холбогдол өгч, хоёр хажуу, ар талыг тэр хэвээр үлдээн чих, шанааг дүрсэлсэнгүй. Нөгөө талаар чулуун онгын дүрслэл нь түүнийг эзэмшигч (бөө) болон шүтэгчдийн ертөнцийг үзэх үзэл, шүтлэг, итгэл үнэмшилд тулгуурласан нь эргэлзээгүй. Онгын нүдийг том хүнхэр аягатайгаар дүрсэлсэн нь нөгөө ертөнцийн хүчирхэг ивээгчийн чухал шинж бололтой. Дээрхийг нэгтгэн үзвэл, чулуун онгод хүний нүүрийг харьцангуй бодит байдлаар харуулдаг боловч хязгаарлагдмал орон зайд рельефийн аргаар өвөрмөц, хүчирхэг, ер бусын дүр төрхийг бүтээж чадсан байна.

Чулуун онго ба зос. Дээд палеолитын үеийн анчин – түүвэрлэгчид өөрсдийн оромж сууц болгон амьдарч байсан, эсвэл тахилга тайлга хийдэг агуй хонгилын хана, тааз, адарт гол төлөв улаан өнгийн зосон² зураг үлдээсэн байдаг. Энэ нь эртний дэлхий дахины нэлээд түгээмэл шинжтэй үзэгдэл бөгөөд Монгол Алтайн нурууны Хойд Цэнхэрийн агуйн зураг манай орны хувьд энэ төрлийн дурсгалын томоохон төлөөлөл юм (Окладников 1972: 76).

Хэн бүхний мэдэх дээр дурдсан зосон зургаас гадна дээд палеолитын үеийн анчин – түүвэрлэгчдийн бууц суурингийн үлдэгдлийг малтан шинжлэх явцад

¹Рельеф (фр. relief, лат. relevo)-ийн арга. Хавтгай гадаргаас товойлгон гаргасан дүрслэл буюу баримлын нэгэн төрөл юм. Энэ нь хоёр хэмжээст суурь дээр хийсэн гурван хэмжээст дүрслэл бөгөөд урлаг, уран барималд өргөн ашиглааг.

²Зос нь байгалийн гаралтай, өнгөт чулуулаг буюу шаварлаг эрдэс юм. Улаан өнгөтэй зос ихэнхдээ төмрийн исэл буюу гематит (FeO) агуулсан байдаг.



Зураг 3. Цагаан толгойн чулуун онго
(Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Цагаан толгойн чулуун зэвсгийн суурин ©Я.Цэрэндагва нар 2024)

байгалийн эрдэс зосны үлдэгдэл их, бага хэмжээгээр олддог. Сэлэнгэ мөрний дунд урсгал Их Төлбөрийн гол, Эгийн голын сав нутгийн дээд палеолитын суурингаас чулуун зэвсэг, амьтны ясны хамт зос илэрсэн ба зосоор будсан зүүлт, чимэглэл олджээ. Сонирхолтой нь эдгээр дурсгалын ойр хавьд зосны орд байдаггүй (Одсүрэн нар 2022: 21-25). Үүнээс үзвэл, зосыг дээд палеолитын үеийн анчин – түүвэрлэгчид өөрсдийн отог бууцандаа холоос зориуд зөөвөрлөн авчирч хэрэглэдэг чухал ач холбогдолтой зүйл байв.

Умард Монголтой хил залгаа орших Байгал нуур орчмын Мальта, Буретийн суурины 23-19 мянган жилийн өмнөх үед холбогдох давхаргаас ясаар хийсэн 30 гаруй хүний дүрст эдлэл олдсон бөгөөд заримынх нь гадар дээрээс улаан, ногоон, хөх өнгийн будгийн үлдэгдэл илрүүлсэн юм. Зөвхөн хүний дүрс төдийгүй бугуйвч, үсний зүүлт дээр ч будгийн ором байжээ (Lbova & Volkov, 2017: 169-178). Түүнчлэн уг дурсгалын оромж сууцын үлдэгдлийг малтан шинжлэх явцад зосны үлдэгдэл илэрч байсан нь Их Төлбөр, Эгийн гол зэрэг Умард Монголын палеолитын соёлт давхаргатай дурсгалтай төстэй ажээ.

Зосыг шүтлэг бишрэл, гоо зүйн үүднээс тодорхой бэлгэдэл өгч ашиглах явдал неолитын үед ч үргэлжилсэн бөгөөд бидний хэлэлцүүлж буй сэдэвт мөн хөндөгдөнө. “Норовлингийн чулуун онго”-ны гадар улаан зосоор будагдсан байсныг хүүр оршуулах нүх болон хүүрийн дээрээс цацсан их хэмжээний зостой холбон тайлбарладаг. Гэтэл “Өлзийтийн Шар манханы онго”-ы ар талд улаан зосны ул мөр үлджээ.

Энэ нь уг чулуун онгыг тодорхой сүсэг бишрэл, зан үйлийн үүднээс зосоор будаж байсны баримт юм. Нэмж өгүүлэхэд, уг онго булшнаас бус неолитын ил суурингаас түүвэр байдлаар илэрч олдсоныг сануулъя. Үүнээс үзвэл, “Норовлингийн чулуун онго”-ын улаан зосыг оршуулгын зан үйлээс наалдаж үлдсэн төдийгөөр үзэх нь өрөөсгөл буюу зориуд будсан байсныг үгүйсгэх аргагүй байна.

Лавтай мэдэгдэж буйгаар хүүр оршуулахад зос цацах ёс неолитын үеэс эхэлж, энеолитийн үеийн Афнасьевийн булш (Новгородова 1989: 81-89), хөгжингүй хүрлийн үеийн Сагсай хэлбэрийн булш (Гантулга 2020: 9-21), хожуу хүрэл, түрүү төмрийн үеийн дөрвөлжин булшинд (Наваан 1975: 200) уламжлагджээ. Оршуулгад цацсан зос цусыг бэлгэдсэн, амилуулах утга санааг илэрхийлдэг (Дулам 2000: 50) хэмээх үзэл хандлага түгээмэл байдаг. Ер нь чулуун зэвсгийн үед зосоор цусыг төлөөлүүлж, дахин төрөхийг бэлгэддэг үзэл бий болж, түүхийн урт удаан хугацаанд үргэлжилсэн билээ. Нэгэнт зос цусыг төлөөлж, амьдралыг бэлгэддэг тул түүгээр чулуун онгыг будаж амилуулдаг зан үйл байх нь зүйн хэрэг болно. Зосоор цусыг төлөөлүүлэн чулуун онгыг будаж амь оруулахаас гадна улаан өнгө нь түүний ер бусын шинжийг улам тодруулж, шүтэгчдэд гүн гүнзгий сэтгэгдэл, сүсэг бишрэлийг төрүүлдэг байсан бололтой.

Бүс нутгийн ижилсэх олдвор, судалгааны товч тойм. Монгол Улсын зүүн, зүүн өмнөд нутгаас илрүүлсэн хүний нүүр дүрсэлсэн чулуун онготой

төстэй эдлэл хөрш зэргэлдээ бүс нутаг, ялангуяа Өвөр Монголын хойд, Хятадын зүүн хойд нутгийн неолитын дурсгалаас олдож байжээ. Эдгээрээс “Өлзийтийн Шар манхан”, “Цагаан толгойн чулуун онго”-той газар нутгийн хувьд хамгийн ойр нь ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Сөнид зүүн, баруун хошууны нутгаас илрүүлсэн дурсгал болно (Цагаан 2019: 176-177). Сөнид зүүн хошууны Баянболд сумын нутгаас 2006 онд неолитын олон төрлийн чулуун зэвсгийн хамт боржин чулууг бөөрөнхий хэлбэрт оруулан засаж хийсэн чулуун онго илрүүлжээ. Толгойн хэлбэрт оруулж зассан уг чулуун эдлэлийн нэг талд нүдний ухархай, амыг дугуй хонхороор үзүүлж хүний нүүрийг гаргажээ (Зураг 4. 1). Сөнид баруун хошууны Наранбулаг сумаас илрүүлсэн өөр нэг онгыг нүдний ухархайг тойрсон давхар хүрээ бүхий том нүдтэй, жижиг амтай, хоёр шанаа хацарт үрчлээс мэт тахиралдсан хэд хэдэн хөндлөн зураастайгаар урлажээ (Зураг 4. 2). Сөнид зүүн хошууны Баян-Уул сумын нутгаас хүнхэр магнайтай жижиг амтай хүний нүүр дүрсэлсэн чулуун онго (Зураг 4. 3) илрүүлсэн нь Цагаан толгойн онготой ихэд төстэй ажээ.

2020 оны байдлаар Зүүн хойд Хятадын нутаг дэвсгэрээс неолитын үеийн хүний дүрстэй шавар, чулуу, ясан эдлэл 200 гаруйг илрүүлж баримтжуулсан байна (李珊珊 2020). Хятадын судлаачид эдгээр хүний дүрст эдлэлийг “нүүрний дүрс”, “толгойн дүрс”, “биеийн дүрс”, “онцгой дүрслэл” хэмээн ангилж, соёлын энэ үзэгдлийг үүсэл, хөгжил, цэцэглэлтийн гэсэн гурван үед хуваан тодорхойлжээ (李珊珊 2020).


1. Үүслийн үе (НТӨ 8 – 6 мянган жил). Зүүн хойд Хятадын неолитын үеийн хүний дүрст эдлэлийн үүсэл Жилин мужийн Байчэн хотын орчимд орших Шуангта (Shuangta, 双塔一期文化) I үеийн соёлтой холбогдоно. Үүнд Хаг I үеийн дурсгал (哈克一期遗存), Шяохэшишийн соёл (Xiaohexi, 小河西文化), Силиангийн соёл (Xiliang, 西梁文化) болон Хэбэй мужийн Бэйфудигийн (Beifudi, 北福地一期文化) I үеийн соёл багтах ба гол төлөв хүний нүүрний дүрстэй шавар эдлэл (Зураг 5. 1-7) сууц оромжийн малтлага, үнстэй нүхнээс олдсон байна. Тэдгээрийн олонхийг шавар ваарын бөөрний хагархайгаар хийсэн

онцлогтой ажээ. Шуангта I соёлын хүний яс, шавар ваар савын хэлтэрхийн дээжийг Бээжингийн Их сургуулийн лабораторид C14, термолюминесценцийн аргаар шинжилж, одоогоос 10 мянга орчим жилийн өмнө холбогдохыг тогтоожээ (Lixin Wang & Mo 2015: 93-101). Энэ нь Их Хянганы нурууны зүүн хормойгоос эх авч Сунгари мөрөнд цутгадаг Нэньжян гол (嫩江 - Nen Jiang)-ын сав нутаг Зүүн хойд Хятадын неолитын үеийн хүний дүрст эдлэлийн хамгийн эртний дурсгал болохыг харуулж байна.

Зүүн хойд Хятадын неолитын үеийн хүний дүрст шавар эдлэлийн үүсэл үеийн төгсгөлд ОХУ-ын Алс Дорнодын Амар мөрний сав газрын Малышевогийн соёлын дурсгал багтахаар байна. Өөрөөр хэлбэл, Малышево соёлын хүрээнд багтах Сикачи-Алянаас авсан дээжийн үнэмлэхүй он цаг 7950 ± 80 (Le-1779) үед холбогдохыг тогтоожээ (Popov & Andrei 2008). Энэхүү соёлын бууц суурин, хагас газар сууцны судалгаа 1960-аад оны үеэс эрчимтэй явагдаж бусад олдворын хамт хүний нүүрний дүрстэй шавар эдлэл хэд хэдийг илрүүлж олжээ.

2. Хөгжлийн үе (НТӨ 6 – 4.5 мянган жил).

Зүүн хойд Хятадын неолитын үеийн хүний дүрст эдлэлийн хөгжлийн үеийн гол төлөөлөл нь Хэбэй мужийн Синлунвагийн соёл (Xinglongwa, 兴隆洼文化), Жаобаогоугийн соёл (Zhaobaogou, 赵宝沟文化) (Zhongguo Shehui Kexueyuan Kaogu Yanjiusuo 1997b) юм. Энэ үед нэг ба хоёр талдаа хүний нүүрний дүрстэй чулуун эдлэл, мушгиа маягтай хүний нүүрний дүрслэл, чулуугаар хийсэн хүний толгойн дүрс, шавраар урласан хүний бие зэрэг хүний дүрслэлийн олон хэлбэр бий болж хөгжжээ (李珊珊 2020). Түүнчлэн шавар (Зураг 6. 8, 9)-аас гадна чулуу (Зураг 6. 10-12), хясаа, дун, ясаар (Зураг 6. 13, 14) хүний дүрс урлах болжээ. Судлаачид Синлунвагийн соёлыг одоогоос 8000 – 6800, Жаобаогоугийн соёлыг одоогоос 6800-6000 жилийн өмнөх үед холбогдоно хэмээн үздэг (Gideon Shelach 2000: 370). Мөн ОХУ-ын Алс Дорнод дахь Амар мөрний доод урсгалд орших Сучу арал дээрх газар сууцны малтлага судалгаагаар хүний нүүрний дүрстэй ваарын хагархай (Зураг 6. 1-2) илэрч олдсон бөгөөд неолитын үеийн



Зураг 4. БНХАУ-ын Шилийн гол аймгаас илрүүлсэн хүний толгой, нүүрний дүрст чулуун эдлэл. 1 – толгойн дүрс Баянгол сум, Сөнид зүүн хошуу; 2 – Сөнид баруун хошуу, Наранбулаг сум; 3 – Сөнид зүүн хойшуу, Баян-Уул сум (© Д.Цагаан 2019)



Зураг 5. Зүүн хойд Хятадын неолитын үеийн хүний нүүрний дүрст эдлэл. Неолитын эрт үе (НТӨ 8-6 мянган жил). Шавар. 1 – Шунгтагийн 1-р үеийн соёл (双塔一期文化), 2 - 5 – Бэйфудигийн соёл (北福地文化), 7 – Жингоузи Силиан дурсгал (井沟子西梁遗址). Неолитын дунд үе (НТӨ 6-4.5 мянган жилийн өмнөх үе). Шавар. 8 - 9 – Жаобаогоугийн дурсгал (赵宝沟遗址), Чулуу. 10 – Синлунгвагийн соёл (兴隆洼文化), 11 – Хэтаогийн дурсгал (河套A 地点), 12 – Баянцагааны дурсгал (白音长汗遗址); Яс. 13 – Баянцагааны дурсгал (白音长汗遗址), 14 – Шинлонгвагийн дурсгал (兴隆洼遗址). Неолитын хожуу үе (НТӨ 4.5-2.5 мянган жилийн өмнөх үе). Шавар. 15 – Хоувагийн дурсгал (后洼遗址), 16 – Нюхэляньгийн дурсгал (牛河梁遗址); Чулуу. 17 – Долоон гэрийн дурсгал (七家遗址), 18 – Нюхэляньгийн дурсгал (牛河梁遗址)

Вознесеновкагийн соёлд багтдаг энэ дурсгалын он цаг 54555 ± 155 (SOAN-1658) (Popov & Andrei 2008) юм.

3. Цэцэглэлтийн үе (НТӨ 4.5 – 2.5 мянган жил).

Энэ үед Зүүн хойд Хятадын неолитын соёлд хүний нүүрийг шавар (Зураг 6. 15, 16), чулуу (Зураг 6. 17, 18)-гаар урлах явдал үргэлжилж байсан ч хүний бүтэн биеийн сийлбэр олширч давамгайлах шинжтэй болжээ.

Монгол орны умард хэсэгтэй зах нийлэх Байгал нуур орчмын бүс нутаг, Өмнөд Сибирийн дээд

палеолитын дунд, төгсгөл үед холбогдох зарим дурсгалаас хүний дүрслэл (Lbova 2021: 1-11), неолитын бууц суурингаас хүний нүүр дүрсэлсэн шавар, чулуу, ясан эдлэл нэлээд олдсон боловч Зүүн Азийн бүс нутгаас нэлээд зайдуу алслагдмал тул энэ удаад дэлгэрүүлсэнгүй.

Хожим олон угсаатанд нийтлэг тархсан хүний нүүрний (онго, өвгөд, баг) шүтлэг, түүнд холбогдох шашны зан үйл, ёслол неолитын үеэс хүчтэй хөгжжээ. Зүүн Азийн бүс нутагт ч соёлын энэ үзэгдэл неолитын үед өрнүүн явагдсан бөгөөд Зүүн хойд Хятад, ОХУ-



Зураг 6. ОХУ-ын Алс Дорнодын бүс нутаг Амар мөрний доод урсгалын Вознесенкагийн соёлын хүний дүрслэл: 1, 2 – хүний нүүр дүрсэлсэн будагтай, будаггүй ваарын хагархай

ын Алс Дорнод, Дорнод Монголын бүс нутагт өөр өөрийн өнгө төрхтэй, хоорондоо холбоо хамааралтай хөгжсөн гэж үзэж байна.

Чулуун онго ба хадны зураг. Неолитын үеийн хүний нүүрний дүрслэл бүхий шавар эдлэл, хадны зургийн хүний нүүрний өвөрмөц дүрслэл хоорондоо холбоо хамааралтай тухай судлаачдын таамаг бий (Popov & Andrei, 2008). Бид энэ үзлийг дэмжиж байгаа бөгөөд Дорнод Монголын неолитын үеийн чулуун онготой дүрслэл, үүрэг зориулалт, утга зүйн хувьд хамгийн ойр дурсгал бол хадны зураг дахь хүний нүүрний дүрслэл юм. Түүнчлэн хүний нүүр дүрсэлсэн хадны зураг тархсан нутгаас энд хэлэлцэж буй гурван чулуун онго олдсоныг тэмдэглэх нь зүйтэй. Ер нь Евразийн уудам нутагт хүний нүүр дүрсэлсэн хадны зураг өргөн тархсаныг судлаачид Төв, Дорнод, Өмнөд Монгол; Алс Дорнод; Өвөр Монгол болон Умард Хятад; Баруун Сибирь болон Монгол Алтай гэсэн дэд бүсэд хуваан авч үзжээ (Амартүвшин нар 2020: 17).

Монголын хадны зураг дахь хүний нүүрний дүрслэлийг судлаачид харилцан адилгүй он цагт холбогдуулж байна. Тухайлбал, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Жаргалантын адгийн ширээгийн зургийг неолит, зэс чулууны үед (Төрбат 2017: 64), Төв аймгийн Лүн сумын Элстэйн давааны хадны зургийг неолитын эхэнд (Төрбат 2022: 72), Өмнөговь аймгийн Номгон сумын Хахуулын голын хадны зургийн дурсгалын эрт үеийг неолитын үед (Эрдэнэбат 2008: 32-56), Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Цагаан дэрсний бичигт усны зургийг НТӨ XV-XII зуунд (Амартүвшин нар 2020: 23) холбогдуулжээ. Мөн Умард Хятад, Өвөр Монголын хадны зураг дахь хүний нүүр дүрсэлсэн олон тооны хадны зургийн эртний он цагийг судлаачдын дийлэнх неолитын эхэнд холбогдуулж байна.

Бас нэрт археологич А.П.Окладников Амар, Уссури мөрний сав дахь хүний нүүр дүрсэлсэн

хадны зургийн эхлэлийг 12-10 мянган жилийн өмнө холбогдуулж, ихэнхийг нь 6-5 мянган жилийн өмнө хамааруулж үзсэн (Окладников 1971: 131-132) бол И.А.Пономарева эдгээр зураг 12-10 мянган жилийн өмнөөс анх зурагдсан гэжээ (Ponomareva 2018: 35-46). Үүнээс үзвэл, судлаачид энэ төрлийн хадны зургийг палеолитын төгсгөл, голоцены эхэнд холбогдуулж байна. Тийнхүү Зүүн Азийн оршин суугчдын дунд хад чулуун дээр хүний нүүрийг өвөрмөц маягаар дүрслэн зурах зан үйл палеолитын төгсгөлд үүссэн бол неолитын эхэн үеэс их төлөв шавар, тэр дундаа ёслолын ваар дээр дүрслэх болжээ. Цаашид төрөл зүйл нэмэгдэж, чулуугаар урлах нь олширсон байна.

Одоо Дорнод Монголын неолитын үеийн гурван чулуун онгыг хадны зургийн ижилсэх дурсгалтай харьцуулан үзье. Өлзийтийн “Шар манханы чулуун онго”-ын хүний нүүрний дүрслэл тойм тул хадны зурагтай харьцуулж нарийн ажиглалт хийхэд хүндрэлтэй. Гэхдээ Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант хайрханы 151-р зураг (Цэвээндорж нар 2004: 56, зур. 151), Зүүн хацавчийн 52, 61-р зураг (Цэвээндорж нар 2010: 36, зур. 52, 61), Номгон сумын Цагаан дэрсний бичигт усны 14, 15-р зураг (Амартүвшин нар 2020: 10, зур. 14, 15)-ийн хүний нүүрний тойм дүрслэлтэй ижил төстэй байна (Зураг 7а. 1-7). Түүнчлэн хөрш зэргэлдээ Алашаа уул (Dematte Paola 2000: 1-20), Шиаофэнгша (Тэргүүнбаяр 2013: 299-300) болон Амар мөрний доод урсгалын Сикичи Аяны дурсгалд тойм маягаар дүрсэлсэн хүний нүүрний зураг бүртгэгджээ. Эдгээр зургийн нийтлэг тал нь нүд, амыг хонхойлох, эсвэл тойруулан цоолборлон дүрсэлдэг арга барил юм. Чулуун онго, хадны зургийн хүний нүүрний тойм дүрслэл урлаачийн чадвараас гэхээс онго шүтээний алсарсан бүдэг дүр төрхийн төсөөлөлтэй илүү холбоотой баймаар санагдана.

“Норовлингийн чулуун онго”-той адилтгах хүний

нүүрний дүрслэл хадны зургийн дурсгалд цөөвтөр байна. Амар мөрний сав газрын хадны зураг дотор уг онгын дүгэрэг нүд, нумарсан дүрс (хөмсөг, үрчлээ), унжуу урт өргөн хамар бүхий хүний нүүрний дүрслэл бий. (Зураг 7в. 8-9) Мөн “Норовлингийн чулуун онго”-ын нүдний дээрх нумарсан давхар дүрслэл (хөмсөг, үрчлээ) болон урт магнай, шовх өндөр төгсгөлтэй толгойн хэлбэр, духны үрчлээ зэрэг шинж Цагаан дэрсний бичигт усны хадны зурагт тод ажиглагдана (Зураг 7б. 1-7) Толгойн ийм онцгой хэлбэр онго шүтээний ер бусын байдлыг илтгэх бөгөөд духны олон үрчлээс онго, өвгөдийн туулсан түүхийн урт зам, тэр хугацаанд сайхь онгыг шүтэж, ивээгдэж ирснийг (шүтэгчдийн үе удмыг) харуулсан тэмдэг бололтой.

“Цагаан толгойн чулуун онго”-нд шувтайж нарийссан эрүү, хүнхэр нүд, төвгөр дух, өргөн унжуу

хамар, төвгөр уруулыг ихэд бодитой дүрсэлжээ. Бид үүнтэй ижил төстэй хадны зураг харахан олж үзэж чадсангүй. Энэ эдлэл “Норовлингийн чулуун онго”-оос загвар хийц, хэлбэр төрхийн нэлээд ялгаатай боловч зууван гонзгой толгой, шувтан эрүү, хүнхэр дүгэрэг нүд, өргөн хамар зэргээрээ ерөнхийдөө төстэй юм.

Дорнод Монголын неолитын чулуун онготой яг ижил эдлэл, хадны зураг Зүүн Азийн бүс нутагт байхгүй бололтой. Өөрөөр хэлбэл, эдгээр чулуун онго хэлбэр хийц, дүрслэлийн хувьд дахин давтагдашгүй юм. Чулуун онгууд хоорондоо дүр төрхөөрөө нэлээд ялгаатай буйн шалтгаан нь шүтэгчдийн хийсвэр төсөөллөөр тэдгээрийг цор ганц урласан явдалд оршино. Ийнхүү чулуун онгууд хоорондоо дүрслэлийн талаар ижилсэх хандлага сул боловч



Зураг 7. А. Тойм дүрсэлсэн хүний нүүрний зураг ба Өлзийтийн шар манханы чулуун онго. 1 – Жавхлант хайрханы хадны зураг (© Цэвээндорж нар, 2004); 2, 3 – Зүүн хацавчийн хадны зураг (© Цэвээндорж нар, 2010); 4, 5 – Цагаан дэрсний бичигт ус (© Амартүвшин нар, 2010), 6, 7 – Алишаа уул (© Амартүвшин нар, 2010).

В. Духны үрчлээ дүрсэлсэн хүний нүүрний зураг ба Норовлингийн онго. 1 – 7 – Цагаан дэрсний бичигт ус (© Амартүвшин нар, 2010), 8, 9 – Амар мөрний сав газрын хүний нүүрний дүрст хадны зураг

тухайн цагийн онго шүтлэгийн нэгдмэл үзэл, соёлын үзэгдлийн тархмал шинжээс хамаарч хүний нүүр дүрслэх ерөнхий шинжээр адил байна.

Хүний нүүрний дүрстэй онго шүтлэгийн үүсэл, утга зүйн асуудал. Байгаль шүтлэг, тотем шүтлэг, өвөг дээдсийн шүтлэгийн хэлбэрүүд эртний нийгмийн сүсэг бишрэлийн гол цөм болж байв. Бидний авч үзэж буй хүний нүүр дүрсэлсэн хадны зураг, чулуун онго өвөг дээдсийн шүтлэгээс үүсэж гарсан бололтой. Өвөг дээдсийн шүтлэг нь овог нийтийн сүсэг бишрэлийн хэлбэр бөгөөд эцэг өвгөдийн сүнс одоо амьдарч буй үр хойчийнх нь оршин байх нөхцөл байдалд нөлөөлдөг гэж итгэн бишрэн шүтэх үзэл юм. Оршуулгын ёсны хөгжилтэй холбогдож өвгөдийн шүтлэг үүссэн байх магадлалтай тухай судлаачдын санал нэлээд үндэслэлтэй (Бадма-Оюу, 2016: 59) агаад неолитын үеэс оршуулгын зан үйлийн өвөрмөц хэлбэрүүд үүсэж бүрэлдсэн юм.

Зүүн Азийн бүс нутагт палеолитын төгсгөл, голоцны эхэн үед хад чулуу, агуйн хонгилд хүний нүүрийг өвөрмөц байдлаар дүрслэх болсныг өмнө өгүүлсэн. Яваандаа хад чулуунд хүний нүүрийг дүрслэн сийлэх журмаар гүйцэтгэдэг шүтлэг, зан үйлийн хэлбэр анчин-түүвэрлэгчдийн дунд үүсэж бүрэлджээ. Энэ төрлийн хадны зураг өвгөдийн шүтлэг, зан үйлтэй холбоотой болохыг өөр хоорондоо ялгаатай хүний нүүрний давтагдашгүй чанар ба хүний нүүрний нэг хэв шинжийг дахин давтан зурсан байдал, хүчирхэг далд ертөнцийн төлөөлөгч гэмээр шинж тэмдэг, өгүүлэмжээс харж болно.

Хүний нүүрний дүрслэлтэй хадны зургаас үзэхэд, зарим тохиолдолд анчин-түүвэрлэгчид өвөг дээдсийн дүрийн талаарх төсөөллөө илүү бодитоор урлахын тулд хадны өнцөг, буланг ашиглаж хүний нүүрийг гурван хэмжээст дүрслэлээр харуулахыг оролдож байв. Неолитын үед шавар эдлэлийн арга технологи үүсч дэлгэрэн энэ эрмэлзэл биелэх боломж бүрдсэн юм. Товчхондоо Зүүн Азийн хадны зураг дахь хүний нүүрний (өвгөдийн дүр) дүрслэл неолитын үед шавар, чулуу эдлэл рүү шилжсэн байна.

Нөгөө талаар үржил шимтэй гол мөрөн дагасан, нуур цөөрөм тойрсон сууршил, аж ахуй-технологийн дэвшил, овгийн байгууллын хувирал өөрчлөлтөөр неолитын үеийн нийгмийн харилцаа илүү олон талт баялаг болсон нь тэдний суурин, сууц, булш оршуулгын малтлага судалгааны үр дүнгээс мэдэгддэг билээ. Неолитын үеийн энэ өөрчлөлтөөр өвгөдийн шүтлэг улам бүр гүнзгийрсэн бөгөөд тэдгээртэй байнга ойр байж шүтэж бишрэх, ивээгдэх гэсэн хандлага давамгайлж нийгмийн шүтлэгийн хэрэгцээ өсөн нэмэгджээ. Нийгмийн эл хэрэгцээг хангахын тулд өвгөдийн дүрийг шавраар, аажимдаа чулуу, яс, хясаагаар урлан овгийн нийтийн онго шүтээний байдлаар шүтэх болжээ. Энэ соёлын үзэгдэл Зүүн

Азийн бүс нутгаас Зүүн хойд Хятад, Алс Дорнодын Амар мөрний савын оршин суугчдын нийгэмд илүү хүчтэй явагджээ. Тиймээс ч Зүүн Азийн, ялангуяа Зүүн хойд Хятад, Алс Дорнодын бүс нутгийн неолитын үеийн ил суурин, газар сууц, гал голомт, булшнаас шүтлэгийн зориулалттай шавар, чулуу, ясаар урласан хүний нүүрний дүрс олноор илэрч олдож байна. Тэрчлэн неолитын үеийн нийгэмд тэрхүү онго, өвгөдийн дүрийг хадгалж эзэмших, амилуулах, ивээл гуйх, даатгах, өвчин, бэрхшээл зовлонг арилгах зэргээр элдэв хүслийг биелүүлдэг, түүнтэй харьцаж чаддаг анхны нууц увидастангууд бий болж, нийгэмд байр суурь нь бэхжсэн бололтой. Тухайлбал, Зүүн хойд Хятадын неолитын сууцаас хүний нүүрний дүрстэй шавар, чулуун эдлэлийг тусгай зассан сууринд суулгасны ул мөрийг илрүүлж онго шүтээн, шүтлэг тахилгын үүрэгтэй болохыг үндсэнд нь тогтоожээ. Үүгээр тогтохгүй Зүүн хойд Хятадын Улаан хадын соёлд багтах Ляонин мужийн Нюхэлянгийн дурсгалын малтлагаас бурхны сүм буюу тахилгын газраас илэрсэн хүний нүүрний дүрст шавар эдлэл (Chen 2025: 260-261) тахилын сүмийн цогцолбор, хүний нүүрний шавар дүрсийг тухайн нийгмийн бүтэц, давхраажилтын илрэлд тооцдог билээ.

Байгал нуурын баруун биед орших Мальтын суурингийн дээд палеолитын дунд, төгсгөл үед холбогдох (23-19 мянган жилийн өмнөх үе) сууцны малтлагаас ясаар сийлбэрлэж хийсэн 30 гаруй хүний дүрслэл илрүүлсэн. Хүний дүрслэлийн олон янз байдал, чимэглэл зэрэгт тулгуурлан судлаачид хүн дүрслэх урлаг бол зөвхөн гоёл биш, харин нийгмийн харилцааны бэлгэдэл, хувь хүний байр суурь, бүлгийн хамаарлын илэрхийлэл (Lbova & Volkov, 2017: 169-178) байж болох тухай санал гаргаж байв. Мальтийн сууриныг анх малтан шинжилсэн алдарт археологич М.М. Герасимов баримлууд сууц оромж, ёс заншлын зориулалттай газар, арслан зааны далны ясаар хийсэн багажийн доод талаас, зосонд булагдсан байдалтайгаар зөвхөн нэг газраас бус өөр өөр байдал, хэв маягтай олдсон тул өөр ертөнцөд одсон хүмүүсийн дурсгал, өвөг дээдсийг хүндэтгэх зорилгоор бүтээсэн урлагийн хэлбэр гэж үзжээ (Герасимов 1931). Хожим эдгээр ясан сийлбэрт бодит хүмүүсийг дүрсэлсэн бөгөөд хүний амьдралын янз бүрийн үеийг харуулсан гэсэн сонирхолтой санал дэвшүүлсэн (Lbova 2021: 1-11) юм. Умард Азийн хүн дүрсэлсэн эдлэлийн тухай судлаачдын дунд нэгдмэл санал дүгнэлтэд хүрээгүй боловч ерөнхийдөө өвөг дээдсийн шүтлэгийн хэрэгсэл, бодит хүнийг төлөөлсөн дүрслэл гэх үзэл хүчтэй байна.

Алс Дорнодын Вознесенкагийн соёлын хүний нүүр дүрсэлсэн улаан будагтай, будаггүй шавар ваарын хагархай, хүн болон амьтны дүрслэлийг

А.П.Окладников хөдөлгөөнт урлагийн олдвор хэмээн оновчтой тодорхойлжээ (Okladnikov 1981). Дорнод Монголын неолитын үеийн чулуун онго ч хөдөлгөөнт урлагийн дурсгал мөн бөгөөд чухам энэхүү чанар нь тэдгээрийн давуу тал болж ан гөрөө, холын аянд ч хэрэглэж байсан болов уу.

Дорнод Монголын неолитын үеийн гурван чулуун онгын 1 нь булшнаас, 2 нь ил бууц суурингаас олджээ. Норовлингийн булшийг Дорнод Монголын неолитын үеийн цооног нүхэнд нас барагчийг суугаа байдлаар тавьдаг оршуулгад багтаан үзэж байна. Норовлингийн булшнаас олдсон оосорлож зүүх зориулалттай нэвт нүхтэй чулуун онго (Наваан 1984: 51-52) хадах, зүүх зориулалттай олон төрлийн хясаа чимэглэл, зүүлт сондор зэрэг баялаг чимэглэлийн зүйл нас барагчийн нийгмийн байр суурь, нэр нөлөөг илтгэдэг. Өөрөөр хэлбэл, Норовлингийн булшны чулуун онго, элдэв гоёл зүүсгэлийг нас барагч амьд ахуйдаа хэрэглэж байсан бөгөөд бөө удганы хувцас хэрэглэл, зүүсгэл бололтой. Харин Өлзийтийн Шар манхан, Цагаан толгойн чулуун онго оосорлон зүүх нүх байхгүй ч тэдгээрийн хэмжээ, хэлбэр хийцийг үзвэл мөн л биедээ авч явахад зориулагджээ.

Монгол Улсын нутгаас неолитын үеийн чулуун онго нэмж олдох бололцоотой боловч Зүүн хойд Хятадыг бодвол төдий л элбэг биш бололтой. Тодруулбал, Зүүн хойд Хятадын неолитын үеийн соёлын энэ үзэгдлийн үүсэл ба цэцэглэлтийн үеийн олдвор манай улсын нутгаас олноогүй, зөвхөн хөгжлийн үед хамаарах чулуун онго гурав олоод байна. Үүний учир нь Дорнод Монголын неолитын үеийн нийгэмд Зүүн хойд Хятадын бүс нутгийн адил газар тариалан, гар урлалын хөгжлөөс шалтгаалсан нийгмийн хүчтэй хувирал явагдаагүй, урьдын анчин-түүвэрлэгчдийн нийгэм үндсэндээ хэвээр байсантай холбоотой. Өөрөөр хэлбэл, аж ахуйн хөгжил, нийгмийн хувирал өөрчлөлтөөс эртний нийгмийн шүтлэг бишрэлийн хэрэгцээ, хэлбэр хамааралтай байдаг байна.

Тийнхүү Дорнод Монголын неолитын үеийн дурсгалаас чулуун онго цөөн тоотой олдож байгааг тухайн нийгмийн хөгжил ба шүтлэгийн хэрэгцээтэй холбон ойлгож болох юм. Гэхдээ Дорнод Монголд газар сууц бүхий овгийн суурьшил, шавар урлал, нэхмэл эдлэл, шинэ чулуун багаж, үр тариа, гэрийн үхэр, чимэглэх урлаг зэрэг дэвшилт зүйлийн нөлөөгөөр нийгмийн гүнд шинэ үзэгдэл, харилцаа үүссэнээр шүтлэгийн хэрэгцээ өсөн нэмэгдэж, зэргэлдээ бүс нутгийн адилаар хүний нүүрний дүрс (өвгөдийн дүр) бүхий онго урлаж шүтэх соёлын үзэгдэл явагджээ. Өөрөөр хэлбэл, Дорнод Монголын неолитын үеийн аж ахуй, нийгмийн хөгжилтөөр хүн амын төвлөрөл бүхий хагас суурьшмал, суурин амьдралын голомтууд буй болсноор нийгмийн гишүүдэд өөрсдийн өвгөдтэй байнга харьцах хэрэгцээ өссөн байна. Үүгээр өвгөдийн

дүр бүхий шүтлэгт ариун дагшин газарт явуулдаг урьдын зан үйл, ёслолыг хагас суурьшмал, суурин амьдралд зохицуулан өөрчлөх шаардлага тулгарчээ. Ийм учраас шүтлэгийн зан үйл, ёслол явуулдаг ариун дагшин газар дахь өвгөдийн дүрийг чулуун онго байдлаар урлаж овгийн шүтээн болгон шүтэх хэлбэр рүү шилжиж байжээ. Мөн үүнтэй хамт овгийн чулуун онгыг хадгалан эзэмшиж, түүнтэй харьцаж далдын хүч удисыг нь жирийн хүмүүст хүргэх онцгой чадвартай гэж овгийн гишүүдэд итгэгдсэн анхны бөө буй болов.

Уг асуудлыг Дорнод Монголын неолитын үеийн байгаль, цаг уурын байдал, түүний аж ахуй-нийгэмд үзүүлсэн нөлөөллөөр лавшруулан үзэх боломжтой. Голоцены дунд үе буюу одоогоос 8–4 мянган жилийн өмнө Зүүн Азид хур тунадасны хэмжээ ихссэн нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт хийсэн археологи, георхеологийн судалгааны үр дүнд тодорхой болсон юм (Janz et al. 2021: 1-29). Энэ үед анчин – түүвэрлэгчид намгархаг үржил шим сайтай газар нутаг болон элсэн манханы баянбүрдийг эрчимтэй эзэмшиж эхэлжээ (Rosen et al. 2022: 1462-1476). Молцог элс, Онгон элс зэрэг элсэн тарамцагт орших цэнгэг уст цэгүүдийн ундаргад ойр орших неолитын бууц сууринд энэ байдал тод ажиглагддаг бөгөөд магадгүй анчин-түүвэрлэгчид цаг уур, байгалийн орчны таатай нөхцөл, улирлын байдалд тохирсон хагас суурьшмал амьдралд шилжсэн байна. Түүнчлэн Тамсагбулагийн газар сууц, гэрийн үхэр нь Дорнод Монголын неолитын үеийн суурьшмал амьдралыг гэрчилдэг билээ. Цэвэр усны эх ундарга, томоохон нуур цөөрөм, тэдгээрийн орчмын ан агнуур, хүнсний ургамлын баян бүрдийг түшсэн хүн амын төвлөрөл бүхий хагас суурьшмал, суурин амьдралын голомтууд үүссэнээр тэдгээрийн дотоодод нийгмийн шүтлэгийн хэрэгцээ өсжээ. Үүгээр нэг талаас овгийн онго шүтээнтэй харьцаж, түүнийг овгийн гишүүдтэй холбож ирсэн этгээдийн үүрэг нөлөө дээшилж, нөгөө талаас суурьшмал амьдралын хэв маягт шүтлэгийн урьдын хэлбэрийг нийцүүлэх шаардлага аяндаа үүсчээ. Улмаар онго шүтээнтэй харьцагч цөөн этгээд овгийн гишүүдэд онго шүтээнийг ойртуулж, суурин амьдралын шүтлэгийн хэрэгцээг хангахын тулд овгийн шүтээн өвгөдийн дүрийг чулуугаар урлан, овгийн шүтлэг, зан үйл, шашны хэрэгсэл болгосон байна. Мөн цэвэр усны ундарга, хүнсний хэрэгцээний байгалийн нөөц баялгийг хуваан эзэмших зэрэг овог хоорондын харилцаа ба овгийн доторх ажил үүрэг, хамтын хөдөлмөрийг зохицуулах, нас барагчийг үдэх, овгийн шүтлэг, зан үйл, ёслолыг удирдан явуулах зэргийг залж чиглүүлэх, нийгмийн манлайлал, удирдлагын хэрэгцээ үүгээр давхар шийдэгдсэн байх магадлалтай.

Дорнод Монголын неолитын үеийн чулуун онгын он цаг. “Норовлингийн чулуун онго”, “Өлзийтийн Шар манханы чулуун онго”-ны он цагийг илүү нарийвчлан тогтоохыг оролдъё. “Норовлингийн чулуун онго” бүхий булш бол хүүрийг цооног маягтай давчуу нүхэнд бөгсөөр нь суулгаж, өвдгийг босгон тавьдаг Дорнод Монголын неолитын оршуулгын зан үйлийн хүрээнд хамаарна. Газрын хөрсөн дээр мэдэгдэх тэмдэггүй ийм суугаа оршуулгыг Чойбалсан хотын орчим Баруун Өлзийт уул, Хэрлэнгийн эрэг, Мэнэнгийн талын өмнөд этгээдэд Тамсагбулагт малтан судалсан. Археологичид Баруун Өлзийтийн булшийг оршуулгын зан үйлийг баримтлан неолитын үед, Тамсагбулагийн булш, сууцыг НТӨ 4-3 мянган жилийн өмнө, Хэрлэнгийн эргийн булшийг неолитын түрүү үед холбогдуулсан байна (Дорж 1969). Цооног нүхэнд хүнийг суулгаж оршуулдаг неолитын үеийн зан үйл багагүй газар нутгийг хамарч тархсан бөгөөд ахмад судлаачид неолитын түрүү үеэс төгсгөл хүртэлх урт удаан цаг хугацааны хүрээлэлд холбогдуулж байжээ.

Зөвлөлтийн эрдэмтэн В.В.Волков, Э.А.Новгородова нар Норовлин уулын булшинд дагалдуулсан эд өлгийн зүйл неолитын оршуулгаас төрөл, тооны хувьд баялаг олон бөгөөд хүний нүүрний дүрст чулуун онго Байгал нуур орчмын Глазковын соёлын дурсгалтай төстэй хэмээгээд энеолитын үед холбогдуулах саналтай байв (Новгородова 1989: 78-81). Гэвч Норовлингийн булш дагалдуулсан эд өлгийн зүйл, оршуулгын зан үйлээрээ неолитын үед холбогдох нь сүүлийн хэдэн жилийн зарим судалгааны үр дүнд тодорхой болов. Тухайлбал, Норовлингийн булшны дугуй хэлбэртэй, зах ирмэгийг ташуу зураасаар иржийлгэн чимэглэсэн хясаагаар хийсэн эдлэлтэй хэмжээ, хийцийн хувьд яг адил тэмээн хяруулын өндөгний хальсаар хийсэн чимэглэл Арц Богдын нурууны өвөр биеийн Баруун хүрээний тойрмын неолитын отог буудлаас олджээ. Үнэмлэхүй он цагийн шинжилгээгээр уг эдлэл 9330 ± 50 BP (Poz-170766) – 9810 ± 50 BP (Poz-170509) жилийн өмнө буюу түрүү неолитын үед холбогдоно (Bobrowski et al. 2025: 1-10). Эд өлгийн зүйлийн ижил төстэй байдлаар он цагийг тогтоодог арга зүй голоцны дурсгалуудад зарим талаар тохирдоггүй, алдаа гарч байгааг анхаарах ёстой. Харин энд харьцуулж буй Норовлингийн булш, Баруун хүрээний тойрмын ижил эдлэлийг харьцуулж он цагийг тогтоохоос гадна эдгээр дурсгалт газрын ерөнхий төрх, орших орчин, ландшафтын ижил ба ялгаатай байдлыг давхар харгалзаж байгааг тэмдэглэе.

Д.Түмэн абугай Норовлингийн булшнаас гарсан хүний ясанд антропологийн хэмжилт хийсэн агаад эр хүйсийн бодгаль хэмээн тодорхойлжээ. Хүний ясанд хийсэн үнэмлэхүй он цагийн шинжилгээ НТӨ 5250 – 5000 жилийн өмнө холбогдож байна (Tumen et

al. 2016: 159-164). Монгол-Канадын “Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” төслийн судлаачид 2023 онд Тамсагбулагийн суурингаас цооног нүхэнд суугаа байдлаар оршуулсан эмэгтэй хүний оршуулга шинээр илрүүлсэн ба булшны орчимд малтсан хагас газар сууц, сорилын малтлагын дээжийн он цаг 7.9 – 7.6 мянган жилийн өмнө холбогдоно (Одсүрэн нар 2023: 134-138). Энэ бүгдээс үзэхэд, “Норовлингийн чулуун онго” илэрч олдсон хүүрийг цооног нүхэнд суулгаж оршуулдаг зан үйл наана хэлэхэд неолитын түрүү үеийн төгсгөлд бүрэлдсэн байна. Иймд “Норовлингийн чулуун онго”-ыг энэ цаг хугацаанд хамааруулж болох юм.

“Өлзийтийн Шар манханы онго”-ны хувьд, уг неолитын үеийн суурин Дарьгангын байгалийн цогцолбор газарт хамаардаг учир малтлага судалгаа хийж үнэмлэхүй он цаг тогтоох боломж хязгаарлагдмал байв. Гэхдээ чулуун онго олдсон газраас зүүн хойш (азимутын 510) шулуунаар 3.1 км зайд орших Салаа булгийн дурсгалт газарт 2017, 2024 онд бага хэмжээтэй малтлага судалгаа хийсэн юм. Иймд нэг цаг үеийн ижил төстэй, холгүй оршиж байгаа зэрэг нөхцөл байдлыг харгалзаж Өлзийтийн Шар манханы суурин, тэндээс олдсон чулуун онгын он цагийг Салаа булгийн суурингийн судалгааны үр дүнгээр төсөөлж байна. Молцог элсний араас ундрах тунгалаг уст булгийн орчимд оршиж буй эдгээр суурины баялаг олдвор бүхий хар хөрсөн дээр бүдүүн ширхэгтэй хөрс хуралдсанаараа тун адил. Сүхбаатар аймгийн өмнөд нутгийн элсэн тарамцагт оршдог неолитын дурсгалууд ийм ерөнхий нийтлэг төрхтэй юм.

Салаа булгийн эх, усны ундарга ойр орчмын газар неолитын үед хамгийн их хүний нягтаршилтай суурьшлын бүс байжээ. 2017 онд Салаа булгийн эхэнд хийсэн сорилын малтлагаар илэрсэн нэлээд баялаг олдвор бүхий 1В талбайн хар хөрсөн давхаргын дээжийн C14 задлан шинжилгээгээр НТӨ 4547–4374 (5650 ± 30 BP) он цаг гарсан байна (Janz et al. 2020: 150-164). 2024 онд 10,5 м² талбайд дахин малтлага хийхэд өнгөн хэсгийн сул элсэн хөрсний доор цөөн олдвортой хар бараан давхарга (2-р давхарга), түүний доор 50 см гаруй зузаан шаргал элсэн давхарга (3-р давхарга), түүний доороос баялаг олдвортой хар бараан давхарга (4а, 4b, 4с давхарга)-ыг илрүүлсэн юм. Шаргал элсэн хурдастай харьцуулахад дундаа заагтай хар бараан давхарга баялаг эд өлгийн зүйл агуулж байв. Шавар ваарын хагархай хэдэн янз бөгөөд зарим нь орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, зарим нь арилжаа солилцоогоор хөрш бүс нутгаас оруулж ирсэн гэж үзмээр байна. Дашрамд дурдахад, неолитын үед өнөөгийн Хятадын баруун хойд нутагт (Ганьсу, Цинхай, Нинся орчим) тархсан Мажяогийн соёлоос гаралтай будмал ваар савыг Монголын говь,

тал хээр хүртэл алс хол нутагт арилжаа солилцоогоор түгсэн тухай таамаглал бий (Jaang 2015: 179-213). Умард Хятадын неолитын дурсгалын шавар эдлэлтэй туйлын төстэй улаан будгаар гадрыг нь будсан, нарийн ширхэгтэй шавраар хийсэн нимгэн ваарын хагархай Салаа булагийн малтлагын 4-р давхарга (Одсүрэн нар 2024), Зараа уулын Ил энгэрийн неолитын дурсгалаас илрүүлсэн билээ. Мөн Салаа булагаас хойд зүгт 20 км хүрэхгүй зайд орших Хөндлөнгийн голын Нам ухаагаас Д.Дугарсүрэн гуай хэдэн хэсэг болж хагарсан будагтай ваарын хагархай түүвэрлэн цуглуулсныг нааж сэргээхэд улаанаар дэвсгэрлэж дээр нь хар өнгөөр хээ тавьсан босоо задгай амсартай бүтэн ваар болсон юм. Судлаачид энэ ваарыг Умард Хятадын неолитын үеийн Яншаогийн соёлын Мяодигоу хэлбэрийн ваар савтай ижил төстэйг дурджээ (Содномжамц & Анхсанаа 2021: 17-23).

Салаа булгийн малтлагын 2, 4b талбайн баялаг олдвор бүхий хар хөрсөн давхаргаас илэрч олдсон амьтны ясны хэлтэрхийд C14 шинжилгээ хийхэд 2-р давхарга BP 2490±20 (UOC-29328), 4b үе BP 6220±20 (UOC-29329) жилийн өмнө холбогдох нь тогтоогдсон. Үүнээс үзэхэд, малтлагын 2, 4-р давхарга хоорондоо хэдэн мянган жилийн зайтай бүрэлдсэн бөгөөд антропогений нөлөөтэй үүссэн нь харагдаж байна. Дурсгалын орчин, ландшафтын ижил төстэй байдлаараа Салаа булаг, Өлзийтийн Шар манханы суурин он цагийн хувьд нэг байх бүрэн боломжтой юм. Үүнийг баримталвал, Өлзийтийн Шар манханы чулуун онгыг неолитын дунд үед холбогдуулж болно.

Цагаан толгойн чулуун онгын хувьд, илрүүлсэн судлаачид неолитын үед холбогдох сүсэг бишрэлийн холбогдолтой олдвор болохыг тэмдэглэсэн (Цэрэндагва нар 2024: 26-29) бөгөөд нарийвчилсан он цагийн талаар санал гараагүй байна.

Хэлэлцүүлэг, дүгнэлт

Дорнод Монголын неолитын үеийн булш, суурингаас илрүүлсэн хүний нүүрний дүрс бүхий чулуун сийлбэр шүтлэг бишрэлийн зан үйлтэй холбоотой, овгийн шүтээнийг урлаж биежүүлсэн эдлэл ажээ. Ийм чулуун эдлэлийг археологийн судалгаанд хүний дүрслэлтэй эдлэл (anthropomorphic, антропоморфный) хэмээн тодорхойлж, олдворын нэг төрөл зүйл болгон авч үздэг билээ. Харин Норовлин уулын булшны нас барагчид дагалдуулж тавьсан хүний нүүрний дүрстэй эдлэлийг шүтлэгийн үүрэг зориулалтаар нь “чулуун онго” нэрээр судалгаанд тэмдэглэж хэвшжээ. Сүхбаатар аймгийн Наран сумын нутгаас илэрч судалгаанд шинээр нэмэгдэж буй чулуун эдлэл үүнтэй ижилсэж буй учир “Өлзийтийн Шар манханы чулуун онго” гэж бичив.

Дорнод Монголын неолитын үеийн Норовлингийн

булш, Өлзийтийн Шар манхан, Цагаан толгойн суурингаас илрүүлсэн чулуун онгын талаар дараах хэлэлцүүлэг, дүгнэлтийг дэвшүүлж байна.

Дорнод Монголын неолитын үеийн эдгээр чулуун онго өвөг дээдсээ шүтэж бишрэх овгийн шүтлэг, зан үйл, ёслолын чухал хэрэглэл болж байжээ. Энэ шүтлэг, зан үйл хад чулуунд овгийн шүтээн өвгөдийн дүрийг сийлж сүсэглэж бишрэх, зан үйл, ёслолын хэлбэрээр анчин-түүвэрлэгчдийн дунд анх үүсжээ. Ингэхдээ өвгөдийг тахиж тайх зан үйл, ёслол явуулдаг ариун дагшин газрууд буй болж, тэнд л өвгөдийн дүрийг сийлж шүтдэг байжээ. Улмаар Дорнод Монголын неолитын үед шинээр буй болсон хагас суурьшмал, суурин амьдралын голомтуудад нийгмийн шүтлэгийн хэрэгцээ өссөнтэй холбогдон өвгөдийн шүтлэг, зан үйл, ёслолд чулуун онго нэвтэрсэн байна. Неолитын үеийн хадны зураг, шавар ваар, шавар эдлэл, чулуун онго зэрэг урлагийн зүйлд илэрч буй соёлын энэхүү үзэгдэл Зүүн Азийн бүс нутагт тархмал болон орон нутгийн онцлог шинжтэй хөгжиж байжээ.

Монголын археологийн судалгаанд хуримтлагдаад буй неолитын үеийн чулуун онго, хадны зургийн хүний нүүрний дүрслэлийн дахин давтагдашгүй шинж чанар ба давтамж, дүрслэлийн онцлог, утга агуулгын зангилааг тайлж тухайн нийгмийн шүтлэгийн байдал, түүний хувирал өөрчлөлт, зүй тогтол, үе шатыг тодорхойлох, үүнд он цагийг тогтоосон чулуун онгыг ашиглах хэрэгцээ нэгэнт буй болжээ. Бид хадны зураг дахь хүний нүүрний олон янз, өвөрмөц дүрслэлийг овог бүр онго шүтээнийхээ дүрийг харилцан адилгүй төсөөлж байсантай, хүний нүүрийг нэг хэв шинжээр олон дахин дүрсэлснийг овгийн онго шүтээнийг дүрслэн сийлж явуулсан удаан хугацааны өвгөдийн шүтлэгийн зан үйл, ёслолын давтамжтай холбон үзэж байна.

Талархал

Өгүүллийн үндсэн хэрэглэгдэхүүний нэг Өлзийтийн Шар манханы чулуун онгыг бидэнд үзүүлж, хэвлэн нийтлэх зөвшөөрөл олгосон Сүхбаатар аймгийн Дарьганга сумын ахмад багш Д.Дугарсүрэн абугайд талархал илэрхийлье.

Abstract

A Study of Neolithic human figurines (ongo) from Eastern Mongolia

**Davaakhuu Odsuren, Lisa Janz,
Adiyasuren Altanbagana, Baatar Tsengel and
Khuukhenduu Suvdaa**

This article examines the Neolithic burials of the Norovlin Mountain in the Kherlen River basin in eastern Mongolia, and the stone tools found in the southern steppe region of the Moltsog region, including the Yellow Dune (Shar Mankh) of the Ulziit Spring and Tsagaan Tolgoi. East Asian hunter-gatherers began to depict human facial features on stone at the end of the Paleolithic, and is believed to be associated with ancestor worship, becoming more sophisticated after the beginning of the Neolithic. Human images began to be depicted in clay and as decorative motifs on pottery. Later, due to changes in material culture and technology, hunter-gatherers in the Neolithic began to form human images in stone, as well as in other materials such as bone and shell. The composition of these images changed through the early and middle Neolithic periods. Stone figures can be seen, not only as idols, but also tools that represented the social status of their owners and the work of religious practitioners. The Norovlin stone figure and the Ulziit Shar Mankh stone figure were both painted with ochre, which may have lent beauty and ritual power.

Keywords: Neolithic, anthropomorphic art, cult, man

Ном зүй

Bobrowski, P., J'ordeczka, M., Masoj'c, M., Gunchinsuren, B., Goslar, T., Sikora, R., Muntowski, P., Odsuren, D., Szmit, M., Bazargur, D., Michalec, G., & Szykulski, J. (2025). The earliest Holocene wanderers through the Gobi Desert evidenced by the radiocarbon chronology of the lakeshore settlement near the Tsakhiurtyn Hondi, Mongolia. In: Radiocarbon, 1–10. DOI: 10.1017/RDC.2025.4

Chen, Y. (2025). Cosmology and the orientation of burials in Neolithic China. [Durham theses, Durham University.]. DOI: etheses.dur.ac.uk/15972

Dematte Paola. (2000). Beyond Shamanism: Landscape and Self-expression in the Petroglyphs of Inner Mongolia and Ningxia (China). in: Cambridge Archaeological Journal, 14:1. McDo, 1–20. DOI : 10.1017/S09597743030000??

Gideon Shelach. (2000). The Earliest Neolithic Cultures of Northeast China: Recent Discoveries and New Perspectives on the Beginning of Agriculture. in: Journal of World Prehistory, Vol. 14. (No. 4.), 363–413. DOI: 0892-7537/00/1200-0363\$18.00/0

Jaang, L. (2015). The landscape of China's participation in the Bronze Age Eurasian network. in: Journal of World Prehistory, 28(3), 179-213. DOI: 10.1007/s10963-015-9088-2

Janz, L., Cameron, A., Bukhchuluun, D., Odsuren, D., & Dubreuil, L. (2020). Expanding frontier and building the Sphere in arid East Asia. in: Quaternary International, 559, 150-164. DOI: 10.1016/j.quaint.2020.04.041

Janz, L., Rosen, A. M., Bukhchuluun, D., & Odsuren, D. (2021). Zараа Уул: An archaeological record of Pleistocene-Holocene palaeoecology in the Gobi Desert. in: PLOS ONE, 1–29. DOI: 10.1371/journal.pone.0249848.

Lbova, L. (2021). The Siberian Paleolithic site of Mal'ta: a unique source for the study of childhood archaeology. in: Evolutionary Human Sciences, 3, e9, 1–11. DOI: 10.1017/ehs.2021.5

Lbova, L. V., & Volkov, P. V. (2017). Pigment decoration of palaeolithic anthropomorphic figurines from Siberia. – in: Rock Art Research, 34. (Number 2), 169–178.

Lbova, L. V. (2021). The Siberian Paleolithic site of Mal'ta: a unique source for the study of childhood archaeology. in: Evolutionary Human Sciences, Volume 3, 1–11. DOI: 10.1017/ehs.2021.5

Lixin Wang, & Mo., R. (2015). The Neolithic remains of the Shuangta Site in Baicheng City, Jilin. in: Chinese Archaeology, 2015, 93–101. DOI: 10.1515/char-2015-0010

Okladnikov, A. P. (1981). Ancient Art of Amur Region. Aurora Art Publishers. 160 p.

Ponomareva Irina, A. (2018). Continuity in the Rock Art tradition of the Siberian lower Amur basin. Number 1. Pp. 35-46. in: Rock Art Research, Vol. 35. (Number 1.), 35–46.

Popov, A. N., & Andrei, V. T. (2008). Neolithic cultures of the Russian far East: technological evolution and cultural sequence. in: TÜBA-AR.

Rigaud, S., Rybin, E. P., Arina M. Khatsenovich, A. Q., Paine, C. H., Byambaa Gunchinsuren, S. T., Daria V. Marchenko, Tsendorj Bolorbat, D. O., J. Christopher Gillam, M. I., & Alexander Yu. Fedorchenko, Dashdorjgochoo Odgerel, Roman Shelepaev, J. H. & N. Z. (2023). Symbolic innovation at the onset of the Upper Paleolithic in Eurasia shown by the personal ornaments from Tolbor-21 (Mongolia). in: Scientific Reports, 1–13. DOI: 10.1038/s41598-023-36140-1

Rosen, A. M., Janz, L., & Bukhchuluun, D., Odsuren, D. (2022). Holocene desertification, traditional ecological knowledge, and human resilience in the eastern Gobi Desert, Mongolia. in: The Holocene, Vol. 32. (12.). DOI: 10.1177/09596836221121777

Tumen, D., Tsydenova, N., Erdene, M., Piezonka, H., Lorenz, S., Khenzykhenova, D., & Namzalova, O. (2016). The Stone Age burial of Norvolyn Uul, Eastern Mongolia: New evidence on anthropology, subsistence and environmental setting. in: Ancient Cultures of Mongolia, Baikal Siberia and Northern China. Reports VII International Scientific

Conference. October 3–7. Part 1, 159–164.

Zhongguo shehui kexueyuan kaogu yanjiusuo. (1997b). in: Aohan Zhaobaogou—Xinshiqi shidai juluo (Zhaobaogou—A Neolithic Settlement). Zhongguo dabaike quanshu chubanshe, Beijing.

Амартүвшин, Ч., Батдалай, Б., Батзориг, О., & Дашзэвэг, Д. (2020). Хадны зураг дахь хүний нүүрний баг ба түүнд холбогдох зарим дүрслэлийн тухай. in: Археологи, түүх, угсаатан судлалын сэтгүүл, №16(15). 7–38.

Бадма-Оюу, Б. (2016). Монголчуудын тотем шүтлэг. Эртний урлаг, домог зүй. зан үйл (Ц. Төрбат (ed.)). УБ: 184.

Волков, В. В. (1975). Погребение в Норовлин уула (Монголия). in: Археология Северной и Центральной Азии. 76–79.

Гантулга, Ж. (2020). Сагсай хэлбэрийн булш. In А. Очир & Ц. Төрбат (Eds.), Археологийн судалгаа: Монголчуудын гарад, угсаа соёлын хөгжил. (pp. 9–21). УБ.

Герасимов, М. М. (1931). Мальта. Палеолитическая стоянка (предварительные данные): результаты работ 1928/29 г. in: Власть Труда, 34.

Дорж, Д. (1969). Дорнод Монголын неолитын үеийн булш, сууц. – in: ШУАМ, №3.

Дулам, С. (2000). Монгол бэлгэдэл зүй – II дэвтэр: өнгөний бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй. УБ.

Наваан, Д. (1975). Дорнод Монголын хүрлийн үе. УБ.

Наваан, Д. (1984). Монгол-Зөвлөлтийн археологичдын хамтын ажиллагаа. УБ.

Новгородова, Э. А. (1989). Древняя Монголия (Некоторые проблемы хронологии и этнокультурной истории). Наука. М.: 384.

Одсүрэн, Д. (2021). Норовлингийн чулуун онго. In Монголын археологийн нэвтэрхий толь. (р. 179). Мөнхийн үсэг ХХК.

Одсүрэн, Д. (2024). Шинэ чулуун зэвсгийн үеийн зосон зургийн дүрслэл, утга зүйн асуудал. in: Studia Archaeologica, Tomus XLV, fasc. 3, 26–36. DOI: 10.5564/sa.v45i2.3782

Одсүрэн, Д., Яанз, Л., Агакун, М., Донойдугар, Э., & Амаржаргал, О. (2024). Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа төсөл: Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн өмнөд нутгаар 2024 онд хийсэн археологийн хайгуул, малтлага судалгааны тайлан. Улаанбаатар. 2024. МУБИС-ийн Түүхийн тэнхим.

Одсүрэн, Д., Яанз, Л., & Адъяасүрэн, М. (2023). Монгол-Канадын хамтарсан неолитын шинэ судалгаа: Тамсагбулагийн сууц ба булш оршуулгын дурсгал. in: Монголын археологи – 2023. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 134–138.

Одсүрэн, Д., Яанз, Л., Адъяасүрэн, М., Сугар-Эрдэнэ, М., & Дашзэвэг, Б. (2022). Зараа уул, Тамсагбулагийн сууринд 2022 онд хийсэн чулуун зэвсгийн судалгаа. –

in: Монголын археологи – 2022. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 21–25.

Окладников, А. П. (1971). Петроглифы Нижнего Амура. Л.: 329.

Окладников, А. П. (1972). Центральназиатский очаг первобытного искусства: пещерные росписи Хойт-Ценкер агуй (Сенгри-агуй), Западная Монголия). Новосибирск: 76.

Содномжамц, Д., & Анхсанаа, Г. (2021). Дорнод Монголоос олдсон будмал хээтэй нэгэн ваар. – in: Нүүдэлчдийн өв судлал, Tomus. XX, Fasc. 2. 17–23.

Төрбат, Ц. (2017). Дорнод Монголд нээгдсэн Жаргалантын адгийн хадны зураг. – in: Орос, Монгол, Хятадын хил залгаа бүс нутгийн эртний нийгмүүдийн соёлын хувьсал ба харилцан нөлөөлөл: Төв Ази ба Умард Хятадын хадны зураг. Эмхэтгэсэн Ц.Төрбат, Н.Батболд. УБ: 62–71.

Төрбат, Ц., Нэргүй, О., & Цэлхагарав, Ц. (2023). Монгол Алтайд илэрсэн палеолитын үеийн алганы урвуу дүрслэл (Хөх булгийн хөмөг, Говь-Алтай аймаг). Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 12 (1), No. 3: 36–46. DOI:10.22353/mjaae.2023120103

Төрбат, Р. (2022). Лүнгийн хадны зураг. (Я. Цэрэндагва (ed.)). УБ: 157.

Тэргүүнбаяр (2013). Ингэний голын хадны зураг. Древние культуры Монголии и Байкальской Сибири. IV международная научная конференция. 13-19 Сент. Чита: 374.

Цагаан, Д. (2019). Говийн чулуун зэвсгийн соёл. УБ: 203.

Цэвээндорж, Д., Гарамжав, Д., Гүнчинсүрэн, Б. Цэрэндагва, Я., Гантулга, Ж. Ч.Амартүвшин, Т. М. (2010). Ханбогдын хадны зураг. УБ: 242.

Цэвээндорж, Д., Цэрэндагва, Я., Гүнчинсүрэн, Б., & Гарамжав, Д. (2004). Жавхлант хайрханы хадны зураг. УБ: 313.

Цэрэндагва, Я., Лхүндэв, Г., Далантай, С., & Олзбаяр, С. (2024). Монголын Дорнод бүс нутагт шинээр илэрсэн хуучин чулуун зэвсгийн үеийн өвөрмөц дурсгалын судалгаа. Их мандал уулын палеолитын дурсгал. in: Монголын Археологийн Мэдээ 2024. УБ: 26–29.

Эрдэнэбат, У. (2008). Хахуулын голын хадны зураг. – in: Studia Archaeologica, Tom. (VI), Fasc. 3. 32–56.

李姗姗. (2020). 东北地区新石器时代人像雕塑相关问题研究. 吉林大学 硕士学位论文文.

Received: Nov. 25, 2025; Revised: Dec. 9, 2025; Accepted: Dec. 23, 2025

